

**ГХБХБГ-ЫН 10 ДУГААР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.10.11.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ 7 хоногт ГЗБГЗЗГ-ын ССМХ болон КХ-тэй хамтарсан "2018 оны бэлчээрийн фото мониторингийн зургийг боловсруулах үр дүнг Лэнд менежер программд оруулах" сэдэвт 2 хоногийн сургалтыг сумын бүх газрын даамлуудад амжилттай зохион байгуулагдаж дуусгалаа.</p> <p>Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор “Газрын суурь үнэ, үнэлгээ, газрын төлбөр өөрчлөгдөж батлагдсантай холбогдуулан орон нутагт сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдах газрын үнэлгээний бүс, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолын төслийг боловсруулж сумдын ИТХ-д хүргүүлээд байна.</p> <p>Алтай сумын “Сагсай гол”-ын услалтын системийн ажлын явцыг газар дээр нь шалгаж, холбогдох үүрэг өгөв. Эхний санхүүжилтийг батлав.</p> <p>Дэлүүн, Улаанхус сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг ГЗБГЗЗГазарт хянуулж бэлэн болгов. Төлөвлөлтийн хязгаарын схемийг гаргав.</p> <p>Аймгийн төвийн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн 8 орон сууцны барилгыг буулган шинээр барих, төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох шийдвэрийг аймгийн ИТХ-аас гаргуулав. (Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангав)</p> <p>Төрийн үйлчилгээний барилгын байршил, техникийн нөхцөлийг зургийг батлуулаад хүргүүлэв.</p> <p>Зарим иргэдийн хүсэлтийн дагуу 3 газрын байршлыг</p>	<p align="center">Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

ТОГТООЖ ӨГӨВ.

Иргэн Б.Гылымхантай холбоотой зарим оршин суугчдын шүүхэд гаргасан гомдлын шүүх хуралдаанд аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцов.

Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 12 иргэнд 7930м2, “Газрын кадастрын мэдээллийн сангийн солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан урд өмчлүүлсэн газрын хэмжээ болон багийн дугаарыг засварлаж 7 иргэнд 6533м2 газрын тус тус гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар аймгийн Засаг даргын захирамж гаргуулан өмчлүүлсэн болно.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2018 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН
ШУУРХАЙ

ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
1	Улсын хэмжээнд 2018 оныг Хариуцлагын жил болгон зарласантай холбоотой төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/664 тоот захирамж, аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	7 хоног	Бүх төсөвт байгууллагын дарга нарт	Бүх сумын газрын даамлуудын ажилд хяналт шалгалт, мониторингийн шалгалтыг явуулсан. Улаанхус сумын газрын даамлыг албан тушаалаас нь чөлөөлсөн, Дэлүүн, Сагсай, Булан сумын газрын даамлуудад сахилгын шигтэл ногдуулах арга хэмжээ тооцож албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

2	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Цахилгаан шугам сүлжээний газар болон “Эрчимбаян Өлгий” ХХК зэрэг байгууллагуудад их хэмжээний өртэй байгаа төсөвт байгууллагууд өр, авлагаа барагдуулж, төлбөр тооцоондоо хяналт тавьж ажиллах	7 хоног	Бүх төсөвт байгууллагын дарга нарт	Дээрх байгууллагуудтай холбоотой манай байгууллага өр, авлагаа байхгүй болно.
3	2018 оны 7 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд Өлгий сумын нутаг дэвсгэрт орсон хүчтэй аадар борооны улмаас үерийн усанд нэрвэгдсэн айл өрхүүдэд байгууллагуудаас ямар дэмжлэг, туслалцаа үзүүлсэн талаарх тайлан, мэдээг 2018 оны 10 дугаар сарын 5-ны өдөрт багтаан аймгийн Засаг даргын орлогч А.Камелиятад ирүүлэх	7 хоног	Бүх төсөвт байгууллагын дарга нарт	<p>Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2018 оны 07-р сарын 20-ний өдөр 1-01/944 тоот албан бичгийн дагуу үерт нэрвэгдэж орон гэргүй болсон эд хөрөнгөө алдаж хохирсон айл өрх, ард иргэдэд байгууллагаас 310 000 (гурван зуун арван мянган) төгрөг хандивын мөнгө цуглуулж аймгийн ЗДТГ-ын дансанд шилжүүлсэн болно.</p> <p>Үерийн усанд нэрвэгдсэн 180 өрхөд улаан шугам тавих ажлыг тусгай зөвшөөрөлтэй бүхий компани хийх ёстойг манай байгууллага өөрсдөө санаачилж гүйцэтгэсэн.</p>

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын биелэлтийг ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 10 дугаар сарын 11-ний дотор ирүүлнэ үү.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР